БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН САЙД, БООМТЫН СЭРГЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ХӨРӨӨНЫ ДАРГА Б.ТУЛГА

2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр

“ХИЛИЙН БООМТЫН ДЭД БҮТЦИЙН ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА, НАРАНСЭВСТЭЙ БООМТЫН ТЭЗҮ” ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

1.	**Байгаль орчны үнэлгээ, ТЭЗҮ боловсруулах үндэслэл, зорилго**	**Үндэслэл:** - “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого /УИХ-ын 2020 оны 52-р тогтоол/; - “Шинэ сэргэлтийн бодлого” /УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоол/; - Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр /УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоол/-ийн 3.3.2.8 дахь заалт; - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль. **Зорилго:** Хилийн боомт дэд бүтцийн төслийн хүрээнд Нарансэвстэй боомтыг сэргээж, нээхтэй холбоотойгоор тус боомтын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ хийх, ТЭЗҮ боловсруулах.
2.	**Захиалагч байгууллага**	Боомтын сэргэлтийн Үндэсний хороо
3.	**Ажлын байршил**	Говь-Алтай аймаг, Эрдэнэ сум, Нарансэвстэй боомт
4.	**Байгаль орчны үнэлгээ, ТЭЗҮ боловсруулах хугацаа**	Гэрээнд заасан хугацаанд хийж гүйцэтгэнэ.
5.	**Байгаль орчны үнэлгээ, ТЭЗҮ боловсруулах байгууллага**	- Барилга байгууламжийн ТЭЗҮ боловсруулах тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий хуулийн этгээд байна; - Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийх эрх бүхий мэргэжлийн байгууллага.
6.	**Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хүрээнд**	
6.1.	**Зориулалт**	Боомтын зорчигч болон ачаа тээврийн шалган нэвтрүүлэх барилга, байгууламж, авто зам талбай, инженерийн дэд бүтэц бүхий цогцолбор */цаашид “Хилийн Нарансэвстэй боомтын цогцолбор” гэх/* барих

6.2.	**Хүчин чадал, хамрах хүрээ**	Хилийн боомтын хяналт шалгалтын бүс, боомтын ойр суурьшлын бүс, боомтыг дагасан нэмэлт байгууламж болох чингэлэг тээвэр болон логистикийн бүсүүдийг хамарна.
6.3.	**Барилга байгууламжийн бүрэлдэхүүн**	Боомтын барилга, байгууламж, боомт орчмын авто зам, талбай, инженерийн дэд бүтэц бүхий цогцолбор байна. Төлөвлөлтийн шатанд Захиалагч болон Хилийн хяналтын байгууллагын саналд үндэслэн тогтооно.
6.4.	**Техник эдийн засгийн үндэслэлийн бүрдэл**	ТЭЗҮ боловсруулахдаа төслийг хэрэгжүүлэх хөгжлийн хэрэгцээ, нийгэм, эдийн засгийн үндэслэл, хууль эрх зүйн орчин, зах зээл, дэд бүтцийн хүчин чадал, хангамж зэргийг нарийвчлан судалж, техник, технологийн шийдэл, хүрээлэн буй орчинд нөлөөлөх байдал, байр талбайн хэрэгцээнд тулгуурлан төслийн эдийн засгийн үзүүлэлтүүдийг тооцоолж, шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээ, ажиллах хүч, түүхий эд, зардлын хэмжээ, нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ, эдийн засгийн шинжилгээ зэрэг судалгаануудыг хийж төслийн хэрэгжүүлэх хувилбаруудыг тодорхойлно. Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад дараах ажлуудыг гүйцэтгэсэн байна. - Боомтын одоогийн болон ирээдүйн өсөлтийн судалгаа, тооцоог үндэслэн хэтийн төлөв байдлыг тодорхойлох, саналаа боловсруулах; - Боомтыг дагасан нэмэлт байгууламж болох AGV,5G тээврийн хэрэгсэл, чингэлэг тээврийн терминалууд, тээвэр логистикийн бүс, суурьшлын бүсийн судалгаа дүгнэлт, зөвлөмж гаргах, боомтын үйл ажиллагаатай уялдуулах; - ХЕТ-ний инженер геологийн судалгаа, дүгнэлт болон байр зүйн зургийг ТЭЗҮ-д хамруулж, тусгах; - Байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгах; - Ундны болон ахуйн усны эх үүсвэрийн нөөцийг нарийвчлан тогтоож, тодорхой болгох; - Боомтын цахилгаан хангамжийн төлөвлөсөн эх үүсвэрийг цаашид дотоодын болон бусад эх

		үүсвэрээс хангах боломжит хувилбарыг судалж, саналыг тусгах; - Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагын дагуу төслийн бүтээн байгуулалт явагдах сум, орон нутагт амьдарч буй иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж саналыг тусгах; - Эдийн засгийн шинжилгээ хийх (SWOT, PEST гэх мэт); - Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж, аялал жуулчлалын бүтээгдэхүүний судалгаа, нийгэм эдийн засгийн ач холбогдлыг тодорхойлох. ТЭЗҮ-ийн тайланд дараах утгууд тусгагдсан байна: 1. Судалгаа, үнэлгээ, дүн шинжилгээ; - Эдийн засаг, нийгэм - Хүн ам, хөдөлмөрийн нөөц - Нутаг дэвсгэрийн ашиглалт /газрын нэгдмэл сангийн ангиллаар/ - Салбарын хөгжил /дэд бүтэц, аялал зуучлал, хөдөө аж ахуй г.м./ 2. Төлөвлөлтийн шийдэл, тогтвортой хөгжлийн бодлого; - Эдийн засгийн хөгжил, хөгжлийн тэргүүлэх чиглэл 3. Дэд бүтэц; - Авто зам, логистикийн бүс - Эрчим хүч, сэргээгдэх эрчим хүч - Холбоо мэдээлэл - Ус, хангамж, ариутгах татуурга - Дулаан хангамж - Бусад 4. Нутаг дэвсгэрийн зохион байгуулалт; 5. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчны бүрдүүлэлт; 6. Төсөл хэрэгжилтийн менежментийн төлөвлөгөө; 7. Хөрөнгө оруулалтын тооцоо, үр ашиг, хэрэгжүүлэх үйл ажиллагааны зөвлөмж; 8. Хувилбарт суурилсан дүгнэлт ба зөвлөгөө;

		9. Зайлшгүй гүйцэтгэх шаардлагатай ажил үйлчилгээ болон төслийн схем, зураг боловсруулалт.
6.5.	**Онцгой нөхцөл**	- Байгаль цаг уур, хөрсний бүтэц, газар хөдлөлийн тэсвэрлэлтийн зэрэгтэй уялдуулан төлөвлөх; - Төлөвлөлтийг хийхдээ эдийн засгийн хэмнэлттэй, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэхээр төлөвлөх; - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төлөвлөлтийг заавал тусгах; - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, тав тухтай орчныг бүрдүүлэхээр төлөвлөх; - Барилга, байгууламж, авто зам, талбайн хийц, ашиглах түүхий эд, материал, орд газрын талаар судалж тусгах; - Хамгаалалтын зурвасыг хангуулах, боомтын эзэмшлийн газарт шаардагдах газар чөлөөлөлтийн зардлыг төсөвт тусгах; - Боомтын хуучин барилгуудын болон ахуйн хог хаягдлын талаар судлах, дэвшилтэд аргыг нэвтрүүлэхээр тусгах; - Барилгын талбай чөлөөлөх, хуучин барилга байгууламж зөөх, сэргээх эсэх талаар судалж зөвлөмж гаргах, өртөг тооцоолох; - Онцгой болон Галын аюулгүй байдал агааржуулалтыг бүрэн хангахаар төлөвлөх; - Монгол Улсад мөрдөж байгаа хууль, тогтоол, дүрэм, журам, стандарт, нормыг мөрдөж, тусгаж ажиллах.
6.6.	**Зөвшөөрөлцөх байгууллага**	- Боомтын сэргэлтийн Үндэсний хороо; - Эдийн засгийн хөгжлийн яам; - Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам; - Сангийн яам; - Хилийн боомтын захиргаа; - Хилийн хяналтын байгууллагууд; - Онцгой байдлын ерөнхий газар /галын аюулгүй байдлаар/; - Говь-Алтай аймгийн ЗДТГ; - Зам, тээврийн хөгжлийн төв; - Бусад.
6.7.	**Баталгаажуулалт**	Техник эдийн засгийн үндэслэлд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Шинжлэх ухаан техник, технологийн зөвлөлөөр магадлал хийлгэж баталгаажуулсан байна.

6.8.	**Хүлээлцэх тайлан**	- Техник эдийн засгийн үндэслэлийн тайлан /иж бүрэн баримт бичиг/ 4 хувь болон PDF файлаар хүлээлгэж өгнө. Үүнд 1 эх хувь, 3% нь тод, гаргацтай, эх хувьтай ижил төвшинд байхаар/; - ТЭЗҮ-гийн төвшинд зурж боловсруулсан нэмэлт мэдээлэл, зураг схемүүдийг тайлангийн хавсралтад оруулна.
7.	**Байгаль орчны үнэлгээ хийх ажлын хүрээнд**	
7.1.	**Хамрах хүрээ**	1. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг хийхдээ дараах чиглэлээр судалгаа шинжилгээ хийж тайлан боловсруулна. Үүнд: - Физик газарзүй, ландшафт; - Геологийн тогтоц; - Геоморфологи; - Гидрогеологийн нөхцөл; - Газар доорх усны нөөц, горим, чанар; - Цаг уур, уур амьсгал; - Агаарын чанар; - Хөрсөн бүрхэвч; - Ургамалан нөмрөг; - Амьтны аймаг; - Байгаль түүх, соёлын дурсгалт газар; - Тусгай хамгаалалттай газар нутаг; - Газар зохион байгуулалт; - Нийгэм, эдийн засаг; - Болзошгүй нөлөөлөл зэрэг бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй болно. - Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллага, тухайн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэн, судлаачдын оролцоотойгоор, шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгааны арга зүйг ашиглан судалгаа, шинжилгээг хийнэ. 2. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг үндэслэн Байгаль орчны нөлөөллийн Ерөнхий үнэлгээг хийлгэж, дүгнэлт гаргуулах бөгөөд үүнийг үндэслэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийнэ. 3. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд: - “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн 4, 6, 7, 8, 9, 11 дүгээр зүйл заасныг баримтлан байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийх; - Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйл, Байгаль орчинд нөлөөлөх

		байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, Амьтны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д заасны дагуу үнэлгээг хийх; - Байгаль орчинтой холбоотой бусад холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд тооцоо, судалгаа хийж холбогдох дүгнэлт, зөвлөмжийг гаргах; - Нарийвчилсан үнэлгээг ерөнхий үнэлгээний дүгнэлт болон Монгол улсын хууль тогтоомжоор батлагдсан журам, аргачлалын дагуу гүйцэтгэнэ; - Төслөөс байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учруулж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тодорхойлж, үнэлэх; - Төслийн үйл ажиллагааны явцад баримтлах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ажиллагсдын эрүүл мэнд, ажлын байрны эрүүл ахуйн талаар зөвлөмж, дүгнэлт боловсруулах; - Барилга байгууламжийн ажилд шаардагдах түүхий эд /элс, хайрга, дайрга г.м/, шатах тослох материалын нийлүүлэлт, хадгалалт, ашиглалтын талаар нарийвчлан судалгаа гаргаж, эх үүсвэр бүрийг нарийвчлан тогтоох; - Барилгын ажилд ашиглах элс, хайрга, дайрга болон бусад түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх төслийг боловсруулж хэрэгжүүлэх, тусгай зөвшөөрлөөр олгогдсон этгээдээс авч ашиглах тохиолдолд элс, хайрга, дайрга нийлүүлэх гэрээг урьдчилан байгуулж, тээвэрлэлтийн үеийн тоосжилт, аюулгүй ажиллагааны зөвлөмжийг боловсруулах; - Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг боловсруулж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тооцож төлөвлөх; - Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2 жил тутамд төслийн үйл ажиллагаанд хийх асуудлыг холбогдох зардлын хамт тайланд тусгах; - Барилгын ажлын явцад баримтлах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны заавар, ажиллагсдын эрүүл мэнд, ажлын байрны эрүүл ахуйн талаар зөвлөмж, дүгнэлт боловсруулах; - Төслийг хэрэгжүүлэх шатанд туслах замыг оновчтойгоор шийдвэрлэх, туслах замаас

		болон түр зам, барилгын ажлын явцад үүсэх тоосжилтыг багасгах арга замыг төлөвлөх; - Барилга байгууламж баригдах орчмын гол, сайрын ус хурах талбай, урт, хамгийн их бага дундаж өргөнийг нарийвчлан тогтоох, үерийн усны хамгийн их өнгөрөлтийг тооцож, түүнтэй уялдуулан үерийн ус зайлуулах сувгийг оновчтойгоор байгуулах зөвлөмж боловсруулах, барилгын ажилд шаардагдах усны хэрэглээ, эх үүсвэрийг нарийвчлан тогтоох; - Барилга байгууламжийн ашиглалтын дараах нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг тусгах; - Шаардлагатай тохиолдолд сонгосон газарт ажлын зураг авалт хийж, бодит байдалд нийцсэн тооцоо судалгааг хийх; - Төслийн үйл ажиллагааны явцад гарах ахуйн болон аюултай хог хаягдал, ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж, тусгай ангиллын хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй аргаар цуглуулах, ангилан ялгах, дахин ашиглах, устгах, зайлуулах аргыг нарийвчлан тооцож, төслийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг болгон хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр устгах, зайлуулах талаар зөвлөмж боловсруулах; - Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээнд заагдсан нарийвчилсан үнэлгээ хийх чиглэл, хуваарийг баримтална.
7.2.	**Ач холбогдол**	Төсөл хэрэгжүүлэхээс өмнө Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийснээр төслийн төлөвлөлтийг байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө багатайгаар төлөвлөх, хэрэгжүүлэх явцад гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн улмаас орчны хувьсал өөрчлөлт, бохирдол доройтлыг бодитойгоор тогтоох, шаардлагатай арга хэмжээг цаг алдахгүй авах, төслийн нөлөөлөлд өртөгсөд, сонирхогч талуудыг бодитой мэдээллээр хангах.
7.3.	**Ажиллах хүрээ**	- Боомтын сэргэлтийн Үндэсний хороо; - Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам; - Орон нутгийн Засаг захиргааны байгууллага; - Орон нутгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар; - Хилийн хяналтын байгууллагууд.
7.4.	**Бүтээгдэхүүн**	Дараах тайлангуудыг шаардлагад нийцүүлэн боловсруулж захиалагч байгууллагад танилцуулан, холбогдох байгууллагын саналыг авч

		баталгаажуулан төлөвлөгөөт хугацаанд хүлээлгэн өгнө. Үүнд: 1. Эхлэлийн тайлан; 2. Явцын тайлан; 3. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан; */Байгаль орчны төлөв байдлын тайланг гэрээ байгуулснаас хойш 30 хоногт багтаан гүйцэтгэх/* 4. Байгаль орны нөлөөллийн Ерөнхий үнэлгээ, дүгнэлт; 5. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, дүгнэлт, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамт; */Ерөнхий үнэлгээний дүгнэлт гарснаас хойш 60 хоногт багтаан гүйцэтгэх/* 6. БОУАӨЯ-ны мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх; 7. Эцсийн тайлан.
7.5.	**Тайлагнах**	1. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, менежментийн төлөвлөгөөг эрх бүхий байгууллагаар батлагдсанаас хойш ажлын 14 хоногт багтаан төсөл хэрэгжих сумын Засаг даргын тамгын газарт хүргүүлнэ. 2. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн танилцуулга, жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлан, баталгааны тусгай дансны мэдээллүүд, төсөл хэрэгжүүлэгч болон зөвхөн төсөл хэрэгжих талбайн талаарх холбогдох мэдээллийг мэдээллийн санд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг батлагдсанаас хойш 1 сарын дотор оруулна.
7.6.	**Ажлын тайлангийн иж бүрдэл**	1. Гэрээт ажлын дагуу гүйцэтгэсэн ажлын даалгаварт тусгасан тайланг цаасан болон электрон хэлбэрээр тус бүр 4 хувь захиалагчид хүлээлгэн өгөх бөгөөд холбогдох зураг, схемийг хавсаргасан байна. 2. Ажил гүйцэтгэх явцад авсан фото, зураг, видео бичлэгийг эх файлаар захиалагчид хүлээлгэн өгнө.
7.7.	**Ажиллах хугацаа**	Тус ажлыг гэрээ байгуулагдсан өдрөөс хойш гэрээний хугацаанд багтаан (БОУАӨЯ-аар батлуулах хугацаа орсон) хийж гүйцэтгэнэ. Тендерт оролцогч ерөнхий гүйцэтгэгч компанийн ажлын төлөвлөгөөтэй

		уялдуулан нэгдсэн ажлын график төлөвлөгөөг ирүүлнэ.
7.8.	**Гарах үр дүн**	1. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан; 2. Байгаль орчны нөлөөллийн Ерөнхий үнэлгээ, дүгнэлт; 3. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамт; 4. Эцсийн тайлан.